

**МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ
УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАН
СУДАЛСАН ТАЙЛАН**

2026 он

**МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ
УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАН
СУДАЛСАН ТАЙЛАН**

НЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Иргэд орон нутгийн асуудалд шууд болон төлөөллийн байгууллагаараа дамжуулан оролцох эрхийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого зэрэг эрх зүйн болон бодлогын баримт бичгүүдэд тодорхойлон заажээ. Гэтэл иргэдийн оролцооны хуульд заасан хэлбэрүүд тогтмол, үр нөлөөтэй хэрэгждэггүй, цахим оролцооны нэгдсэн платформ, тогтолцоо бүрдээгүй, төрийн байгууллагын ил тод байдал, мэдээллийн хүртээмж хангалтгүй, иргэдийн санал, санаачилгыг шийдвэр гаргалтад тусгах, эрхээ эдлэх боломжийг бүрдүүлэх асуудал дутмаг байсаар байгаа нь энэ хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хууль зүйн үндэслэл болж байна.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 2020 оны шинэчилсэн найруулга нь иргэд орон нутгийн асуудалд шууд оролцох эрх зүйн үндсийг өмнөх хуультай харьцуулахад илүү тодорхой болгож, нутгийн өөрийн удирдлагыг хэрэгжүүлэх иргэний эрх, оролцоо болон оролцох хэлбэрүүдийг өргөжүүлэн тусгасан байна. Тухайлбал, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын санал асуулга, төсөв, Захиргааны ерөнхий хуулиар тодорхойлсон төлөвлөлтөд оролцох, орон нутгийн хөгжлийн бодлогод саналаа өгөх, мэдээлэл авах ил тод байдлыг нэмэгдүүлэх зэрэг олон механизмуудыг хуульчилсан нь орон нутгийн засаглалыг ардчилсан, хариуцлагатай болгох чиглэлд ахиц авчирсан гэж үзэх боломжтой.

Шинэчилсэн найруулгын 28-31 дүгээр зүйлүүд нь нутаг дэвсгэрийн өөрийн удирдлагын үндэс болох нутгийн өөрөө удирдах ёсыг тодорхойлж, иргэдийн оролцооны эрх, хэлбэр, механизмд чиглэсэн байдаг. Эдгээр зүйлүүд нь Монгол Улсын Үндсэн хуулийн иргэдийн эрх, ардчиллын зарчим, түүний үндсэн агуулгатай уялдуулан орон нутгийн бие даасан шийдвэр гаргах эрх, иргэдийн шууд болон төлөөллийн оролцоог баталгаажуулдаг.

28 дугаар зүйл нь “нутгийн өөрөө удирдах ёс”-ыг тодорхойлсон үндсэн заалт юм. Энэ заалтаар иргэдийн эрхийг тодорхойлохоос гадна санхүү, нөөц, механизмуудтай холбоотойгоор тэдний бие даан шийдвэрлэх бодит чадварыг тодорхойлжээ. 29 дүгээр зүйл нь Үндсэн хуулиар баталгаажсан иргэдийн шууд болон төлөөллийн оролцооны эрх буюу сонгох, сонгогдох, орон нутгийн асуудлаар санал гарган шууд оролцох, өргөдөл гомдлоо шийдвэрлүүлэх, мэдээлэл авах эрхүүдийг тодорхойлсон байдаг. 30 дугаар зүйлд шууд ардчиллын зарчмыг хэрэгжүүлж баг, хорооны ИНХ-д саналаа хэлэх, тодорхой асуудлаар санал гарган ИТХ-аар хэлэлцүүлэх, тулгамдсан асуудлаар санаачилга гаргах зэрэг нутгийн өөрийн удирдлагад оролцох төлөөллийн хэлбэрүүдийг тодорхойлсон. 31 дүгээр зүйл нь нутгийн өөрийн удирдлага дахь иргэний оролцоо, ИТХ, ИНХ зэрэг нутгийн

өөрөө удирдах байгууллагуудын үүрэг, иргэдийн санал, санаачилга гаргах механизмууд, зөвлөлдөх санал асуулга явуулах зэргээр иргэдийн оролцоог хууль эрх зүйн механизмтай болгож, шууд ардчиллыг бэхжүүлсэн байдаг.

Ийнхүү хуульд иргэдийн оролцоог илүү нарийвчилж тодорхой болгосон нь өмнөх зохицуулалтуудаас ахицтай боловч энэхүү эрх зүйн боломж бодит амьдрал дээр бүрэн хэрэгжихгүй, “цаасан дээрх амьгүй заалт” хэвээр байсаар байна. Энэ нь иргэдийн оролцоог хангах бодит хэрэгжилтийн механизм, арга зам, цахим болон институцийн платформыг бүрдүүлж өгөөгүй байгаатай холбоотой гэж үзэж байна.

ХОЁР. АСУУДАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Монгол Улсад иргэд төрийн үйл хэрэгт оролцох эрх нь Үндсэн хуулиар баталгаажсан бөгөөд иргэн шууд болон төлөөллийн байгууллагаараа дамжуулан төрийг удирдах хэрэгт оролцох боломжтой гэж хуульчилсан байдаг. Гэвч орон нутгийн түвшинд энэхүү эрх бодит амьдрал дээр бүрэн хэрэгжихгүй, иргэдийн оролцоо хэлбэр төдий, үр нөлөө багатай хэвээр байна. Одоогийн зохицуулалтын хүрээнд иргэд иргэдийн Нийтийн Хуралд оролцох, санал гаргах, өргөдөл гомдол хүргүүлэх зэрэг боломжтой боловч эдгээр механизмууд нь тогтмол, системтэй, үр дүнтэй хэрэгжих институцийн түвшний баталгаатай хэлбэртэй болж чадаагүй байна.

Ялангуяа иргэдийн хамтын санаачилгад суурилсан нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлыг төрийн шийдвэр гаргалтад хүргэх тодорхой, шат дараалсан, заавал хэрэгжих механизм эрх зүйн зохицуулалтад байхгүй байгаа нь энэхүү асуудлын гол цөм болж байна. Үүний улмаас иргэд орон нутгийн түвшинд шийдвэрлэгдэх ёстой асуудлаа Улсын Их Хурлын дэргэдэх нийтийн өргөдлийн цахим системээр дамжуулан тавих явдал түгээмэл болсон нь харьяаллын буюу эрх хэмжээний зөрчил үүсгэж байна.

Нөгөө талаар 2020 оны шинэчилсэн найруулгаар иргэдийн оролцоог хуульчлан өргөжүүлсэн боловч энэ нь хэрэгжилтийн бодит механизмгүй тул “цаасан дээрх” зохицуулалт хэвээр үлдсэн гэж үзэх үндэслэлтэй байна. Түүнчлэн цахим оролцооны платформууд тодорхой хэмжээнд бий болсон боловч эдгээрийг хуульчлан зохицуулаагүй, үр дүнг шийдвэр гаргалтад заавал ашиглах императив шинжгүй байгаа нь иргэдийн итгэл, оролцооны идэвхэд сөргөөр нөлөөлж байна.

Иймд тухайн асуудлын мөн чанар нь иргэдийн оролцох эрхийн хэрэгжилтэд бус, харин түүнийг хэрэгжүүлэх институцийн механизм, эрх зүйн зохицуулалтын дутмаг байдалд оршиж байна гэж дүгнэж байна.

ГУРАВ. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГО

Дээр дурдсан нөхцөл байдлаас үзэхэд энэхүү хуулийн төслөөр шийдвэрлэх зорилго нь орон нутгийн түвшинд иргэдийн төрийн шийдвэр гаргалтад оролцох эрхийг бодитой, үр нөлөөтэй хэрэгжүүлэх институцийн болон эрх зүйн механизмыг бүрдүүлэхэд оршино. Энэ зорилгын хүрээнд иргэдийн хамтын санаачилгад тулгуурласан нийтийн өргөдлийн тогтолцоог бий болгож, тухайн өргөдөлд тодорхой тооны иргэн дэмжлэг үзүүлсэн тохиолдолд нутгийн өөрөө удирдах байгууллагын

түвшинд заавал хэлэлцүүлэх, шийдвэрийн үр дүнг ил тод мэдээлэх зохицуулалтыг хуульчлах шаардлагатай байна.

Мөн цахим оролцооны боломжийг хууль зүйн хувьд баталгаажуулж, биечлэн оролцох боломжгүй иргэдийн оролцоог хангах, төрийн шийдвэр гаргалтыг ил тод, хариуцлагатай болгох нөхцөлийг бүрдүүлэх нь уг зорилгын салшгүй хэсэг болно.

ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫН ХАРЬЦУУЛАЛТ

Асуудлыг шийдвэрлэх хүрээнд хэд хэдэн боломжит зохицуулалтын хувилбарыг авч үзэх боломжтой.

Нэгдүгээрт, одоо хэрэгжиж буй зохицуулалтыг хэвээр хадгалах буюу шинэ зохицуулалт хийхгүй байх. Уг хувилбар нь хууль тогтоомжийн хувьд нэмэлт, өөрчлөлт шаардахгүй боловч иргэд, олон нийтийн оролцооны өнөөгийн байдал буюу харьцангуй сул байгаа нь өөрчлөгдөхгүй. Иймд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх боломжгүй.

Хоёрдугаарт, эрх бүхий этгээдийн журам, бодлого, захиргааны шийдвэрээр асуудлыг зохицуулах хувилбар юм. Энэ нь хэрэгжих боломжит хугацааны хувьд илүү хурдан боловч нийтээр дагаж мөрдөх, эрх зүйн баталгаа бүхий тогтолцоог бүрдүүлэх боломжгүй, улмаар тогтвортой хэрэгжилт, үр дүн хангалтгүй байна.

Гуравдугаарт, тухайн орон нутгийн түвшинд эрх бүхий байгууллагын бие даасан шийдвэрээр зохицуулах. Энэ хувилбарын хувьд орон нутаг бүр өөр өөр стандарт тогтоох, ойлголтын зөрүү үүсгэх, иргэдийн эрх тэгш байдал алдагдах эрсдэлтэй.

Дөрөвдүгээрт, хууль тогтоомжийн түвшинд зохицуулах хувилбар нь иргэдийн оролцох үндсэн эрхийг хэрэгжүүлэх баталгааг хангах, орон нутгийн засаглалын байгууллагуудын үүрэг, хариуцлагыг тодорхой болгох, улс орны хэмжээнд нэгдмэл стандарт тогтоох боломжтой хамгийн үр нөлөөтэй хувилбар гэж үзэв.

Иймд дээрх хувилбаруудаас асуудлыг үр дүнтэй шийдвэрлэх цорын ганц тохиромжтой арга зам нь хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах замаар зохицуулах шаардлагатай гэж дүгнэв.

ТАВ. ҮР НӨЛӨӨНД ХИЙСЭН УРЬДЧИЛСАН ҮНЭЛГЭЭ

Энэхүү зохицуулалтын хувилбар нь хүний эрх, нийгэм, эдийн засагт дараах байдлаар нөлөөлнө.

Хүний эрхийн хувьд иргэдийн төрийн хэрэгт оролцох, санал гаргах, шийдвэрлүүлэх эрх бодитой хэрэгжих бөгөөд оролцоог өргөжүүлсэн, ил тод байдлыг нэмэгдүүлсэн эерэг нөлөөтэй болох нь тогтоогдож байна. Гэвч цахим оролцоог нэвтрүүлэхтэй холбогдон орон нутгийн болон алслагдсан бүс нутгийн иргэдийн хүртээмжийн ялгаа үүсэх эрсдэл байгаа тул энэ нь хосолмол буюу танхимын болон цахим хэлбэрийг уялдуулах замаар зохицуулагдах шаардлагатай.

Эдийн засгийн хувьд энэхүү зохицуулалт нь шууд санхүүгийн их хэмжээний үр дагавар үүсгэхгүй боловч цахим системийг хөгжүүлэх, нэвтрүүлэх, хүний нөөц бэлтгэх зэрэг анхны зардал шаардагдана. Харин урт хугацаандаа иргэдийн оролцоонд суурилсан бодлого илүү оновчтой болж, төсвийн үр ашигтай хуваарилалтад эерэг нөлөө үзүүлэх боломжтой.

Нийгмийн хувьд иргэдийн оролцоо нэмэгдэж, орон нутгийн ардчилал бэхжин, төрд итгэх итгэл өсөх, шийдвэр гаргалт ил тод болох давуу талтай. Гэхдээ иргэдийн саналын чанар, тоо нэмэгдэхийн хэрээр популист хандлага, үндэслэлгүй санаачилга өсөх эрсдэл байж болзошгүй бөгөөд энэ нь зохицуулалтын дотор зохих шүүлтүүр, шаардлагаар дамжин шийдэгдэх боломжтой.

Байгаль орчны хувьд шууд нөлөөлөлгүй гэж үзэв.

Зохицуулалтын хувилбар нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад холбогдох хууль тогтоомжтой нийцэж байгаа бөгөөд иргэдийн оролцоог өргөжүүлэх чиглэлд олон улсын сайн засаглалын зарчимтай нийцэж байна.

Хүснэгт 1

ХҮНИЙ ЭРХЭД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр дүн	Холбогдох асуулт	Хариулт	Тайлбар	
1.Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж байгаа эсэх	1.1.Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх			
	1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Тийм		Ялгаварлан гадуурхахыг уриалсан агуулгатай өргөдлийг хүлээн авахгүй байхаар зохицуулсан
	1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх		Үгүй	

	1.1.3.Тодорхой эмзэг бүлгийн нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээ бол олон улсын болон үндэсний хууль тогтоомжид заасан хүний эрхийн хэм хэмжээтэй нийцэж байгаа эсэх		Үгүй	Тодорхой эмзэг бүлгийн нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээ биш
	1.2.Оролцоог хангах			
	1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх	Тийм		Нийтийн оролцоог нэмэгдүүлэх зорилготой цахим өргөдлийн хэлбэрийг нэвтрүүлнэ
	1.2.2.Зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх		Үгүй	
	1.3.Хууль дээдлэх зарчим ба сайн			
	1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Тийм		
	1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, хүний эрхийг хамгаалах механизмийн талаар НҮБ-аас өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	Тийм		
	1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх		Үгүй	

2.Хүний эрхийг	2.1.Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах тохиолдолд энэ нь хууль ёсны ашиг сонирхолд нийцсэн эсэх		Үгүй	Хүний эрхийг хязгаарлаагүй
	2.2.Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх			Хамааралгүй
3.Эрх агуулагч[8]	3.1.Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх		Үгүй	Хамааралгүй
	3.2.Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх		Үгүй	Хамааралгүй
	3.3.Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх		Үгүй	Хамааралгүй
	3.4.Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх (хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй)		Үгүй	Хамааралгүй
4.Үүрэг хүлээгч[9]	4.1.Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	Тийм		
5.Жендэрийн	5.1.Жендэрийн үзэл баримтлалыг тусгасан эсэх		Үгүй	
	5.2.Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх		Үгүй	

ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр дүн	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
	1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)		Үгүй	
	1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх		Үгүй	
2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх		Үгүй	
	2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх		Үгүй	
	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх		Үгүй	
	2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх		Үгүй	
3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх		Үгүй	
	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх		Үгүй	

	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх		Үгүй	
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх		Үгүй	
4.Мэдээлэх үүргийн улмаас үүсч байгаа захиргааны зардлын ачаалал	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх		Үгүй	
5.Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх		Үгүй	
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх		Үгүй	
	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх		Үгүй	
6.Инноваци болон судалгаа шинжилгээ	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх		Үгүй	
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх		Үгүй	
7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх		Үгүй	
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх		Үгүй	

	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх		Үгүй	
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
9.Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	Тийм		
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх	Тийм		
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх	Тийм		
10.Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх		Үгүй	
	10.3.Инфляци нэмэгдэх эсэх		Үгүй	
11.Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	Тийм		

НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр дүн	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх		Үгүй	
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх		Үгүй	
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх		Үгүй	
	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	
	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх		Үгүй	
	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх		Үгүй	
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх		Үгүй	
3.Нийгмийн тодорхой бүлгийг	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх		Үгүй	

хамгаалах асуудал	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэршээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт		Үгүй	
	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх		Үгүй	
4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх		Үгүй	
	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм		Иргэдийн оролцооны улмаас төрийн шийдвэр гаргах үйл ажиллагаанд ахиц, дэвшил гарна. Иргэдийн төрд итгэх итгэлийг нэмэгдүүлэх
	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх	Тийм		
	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх		Үгүй	
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх		Үгүй	
	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	

	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм		Амьдарч буй орчны чанарт эерэг нөлөөлөл бий болгоход чиглэсэн шийдвэр гаргуулахаар нийтийн өргөдөл гаргах байдлаар
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх		Үгүй	
6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	Тийм		Иргэдийн оролцоо нэмэгдсэнээр нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмж нэмэгдэх боломжтой
	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх		Үгүй	
	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх		Үгүй	

7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	
	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх		Үгүй	
	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
	7.4.Гэмт хэргийн хохилогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
8.Соёл	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх	Тийм		Нутаг, ус, түүхийн дурсгалт газрын нэршил өөрчлөх, музей зэрэг соёлын байгууллагуудын үйл ажиллагаанд хамааралтай асуудлаар нийтийн өргөдөл гарсан тохиолдолд

БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр дүн	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1.Агаар	1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх		Үгүй	
2.Зам тээвэр, түлш, эрчим хүч	2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх		Үгүй	
	2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх		Үгүй	
	2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
	2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх		Үгүй	
3.Ан амьтан, ургамлыг хамгаалах	3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх		Үгүй	
	3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сэргөөр нөлөөлөх эсэх		Үгүй	
	3.3.Ан амьтдын нүүдэл, суурьшилд сэргөөр нөлөөлөх эсэх		Үгүй	
	3.4.Тусгай хамгаалалттай газар нутагт сэргөөр нөлөөлөх эсэх		Үгүй	
4.Усны нөөц	4.1.Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сэргөөр нөлөөлөх эсэх		Үгүй	
	4.2.Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх		Үгүй	
	4.3.Ундны усны чанарт нөлөөлөх эсэх		Үгүй	

5.Хөрсний бохирдол	5.1.Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
	5.2.Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх		Үгүй	
6.Газрын ашиглалт	6.1.Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх		Үгүй	
	6.2.Газрын зориулалтыг өөрчлөх эсэх		Үгүй	
	6.3.Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх		Үгүй	
7.Нөхөн сэргээгдэх/нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1.Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхийг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх		Үгүй	
	7.2.Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх		Үгүй	

ЗУРГАА. ГАДААД УЛС ОРНЫ ТУРШЛАГЫН ДҮГНЭЛТ

Олон улсын туршлагаас харахад иргэдийн оролцоонд суурилсан цахим платформууд нь бодлого боловсруулах, төсөв хуваарилах, орон нутгийн шийдвэр гаргалтад иргэдийн саналыг бодитоор тусгах үр дүнтэй механизм болж хөгжсөн байна.

Тухайлбал, Бразил улсын “Brasil Participativo”, Исландын “Better Reykjavík”, Испанийн “Decidim.barcelona” зэрэг платформууд нь иргэдийн саналын өндөр хувь нь бодлогод тусгагдсан, хэрэгжсэн бодит жишээг харуулж байгаа бөгөөд цахим болон танхимын оролцоог хослуулах нь үр дүнд хүрэх гол нөхцөл болохыг баталж байна.

Эдгээр туршлага нь иргэдийн оролцооны механизмыг зөвхөн технологид бус, эрх зүйн болон институцийн баталгаатай уялдуулах шаардлагатайг харуулж байна гэж дүгнэлээ.

ДОЛОО. НЭГДСЭН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Дээрх судалгаа, шинжилгээнээс дүгнэвэл Монгол Улсад иргэдийн орон нутгийн түвшинд төрийн шийдвэр гаргалтад оролцох эрх хуульд заасан боловч хэрэгжилтийн бодит механизм дутагдалтай байгаа нь энэхүү харилцааг шинэ шатанд гарган зохицуулах шаардлагыг бий болгож байна. Журам болон захиргааны шийдвэрийн түвшинд энэ асуудлыг бүрэн шийдвэрлэх боломжгүй бөгөөд иргэдийн үндсэн эрх, засаглалын харилцааг хамарч буй онцлогийг харгалзан үзэхэд уг харилцааг хууль тогтоомжийн түвшинд зохицуулах нь оновчтой байна.

Нийтийн өргөдлийг цахим хэлбэрт шилжүүлснээр Монгол Улсын Үндсэн хуулийн гуравдугаар зүйлийн 1-д “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ”, Арван зургадугаар зүйлийн 9-д “шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй...” гэж заасан эрхийн баталгааг хангаж;

Захиргааны ерөнхий хуульд заасан захиргааны шийдвэр гаргах, захиргааны хэм хэмжээний акт батлах, төлөвлөх, захиргааны гэрээ байгуулах ажиллагаанд оролцоог хангах, олон нийтийн саналыг авах ажиллагааг боловсронгуй болгож, төрд итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлэх, төрөөс иргэдийнхээ санал, хүсэлтэд хариулах, заавал шийдвэрлэх императив зарчмыг тогтоох;

- Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай

Иймд нийтийн өргөдөлд суурилсан иргэдийн оролцооны механизмыг хуульчилж, түүнийг цахим болон танхимын хэлбэрээр уялдуулан хэрэгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх нь зайлшгүй шаардлагатай гэж үзэв.

---o0o---